



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 21 өдөр

Дугаар А/129

Бор-Өндөр сум

Өмчлөлийн газрын байршлыг өөрчлөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.3 дахь хэсэг, Бор-Өндөр сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны "2024 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөө батлах тухай" 14 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмчлөлийн газрын байршлыг тодорхой шалтгааны (үер ус урсдаг, жалгатай) улмаас өөрчлөх хүсэлт ирүүлж, холбогдох баримт материалыг бүрдүүлсэн иргэнд Нэгдүгээр хавсралтад заасны дагуу сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаснаар газрын байршлыг нь өөрчилсүгэй.


2. Энэхүү захирамж гарсантай холбоотой нэгдүгээр хавсралтад дурдсан өмнөх газрын мэдээллийн санд бүртгэгдсэн хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Холбогдох хууль тогтоомжид заасан хүрээнд өмчлөх эрхээ хэрэгжүүлэхийг газар өмчлөгчид, газрын мэдээллийн өөрчлөлтийг улсын бүртгэлд бүртгэх ажлыг зохион байгуулж, газар өмчлөгчийг хуулийн дагуу хүлээсэн үүргээ биелүүлэхэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г.АДЪЯАБИЛЭГТ



Сумын Засаг дарга 2024 оны 09-р сарын 24-ны өдрийн /МХР/ захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар өмчлөгч иргэдийн мэдээлэл

Д/д	Өмчлөгчийн				Өмнөх захирамжийн			
	Ургийн овог	Эцэг эхийн нэр	Нэр	Регистр	Огноо	Дугаар	Хавсралтын дугаар	Холбогдох хэсгийн дугаар
1	2	3	4	5	6	7	8	9
1	Боржигин	Дашнэрэн	Батцэцэг	СК63103104	2014.09.10	162	1	10

Өмнөх газрын			Батлагдсан газрын		
Нэгж талбарын дугаар	Хаяг	Хэмжээ /мкв/	Байршил	Ашиглалтын зориулалт	Үнэ /төгрөг/
10	11	12	13	14	15
2318010326	3-р баг, Говь-2 гудамж, 16 тоот	700	3-р баг Бумбат, Говь-5 гудамж, 528а тоот	Гэр бүлийн хэрэгцээ	2100000